

**БАТЛАВ**

**ДАРХАН УУЛ АЙМГИЙН ХОНГОР СУМЫН  
11 ДҮГЭЭР СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ**

**М.ПҮРЭВБААТАР**

**“ СУРГУУЛИЙН ХҮҮХДИЙН ХООЛ ХҮНСНИЙ МАТЕРИАЛ “  
НИЙЛҮҮЛЭГЧИЙГ СОНГОН ШАЛГАРУУЛАХ  
ТЕНДЕРИЙН БАРИМТ БИЧИГ**

**Төслийн нэр: Сургуулийн хүүхдийн хоол хүнсний  
материал нийлүүлэх**

**Төслийн дугаар: ДААХО11С/202012013**

**2020.01.31**

## СОНГОН ШАЛГАРУУЛАХ ТЕНДЕРИЙН БАРИМТ БИЧИГ

## Нэг. ҮНИЙН САНАЛ АВАХ УРИЛГА

**Дархан Уул аймгийн Хонгор сумын 11-р сургууль** нь сонгогдсон эрх бүхий тендерт оролцогчдоос **сургуулийн гал тогоонд хоол хүнсний материал**-ыг нийлүүлэх тухай битүүмжилсэн үнийн санал ирүүлэхийг урьж байна.

Тендерийн баримт бичгийг эргэж төлөгдөхгүй нөхцөлтэйгээр 50,000 төгрөгөөр худалдана.

Тендерт оролцогч нь санхүүгийн болон туршлагын хувьд дараах шаардлагыг хангасан байна.Үүнд:

1. Борлуулалтын хэмжээ:2019 оны борлуулалтын орлогын дундаж нь төсөвт өртгийн 50 хувиас багагүй
2. Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн хэмжээ:Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн хэмжээ нь төсөвт өртгийн 40 хувиас багагүй.
3. Сүүлийн жилүүдэд хэрэгжүүлсэн ижил төстэй ажлын өртөг: 2019 оны дундаж нь төсөвт өртгийн 50 хувиас багагүй үнийн дүнтэй ижил төстэй ажлыг гүйцэтгэсэн байх
4. Тусгай зөвшөөрөл шаардлагатай бол тусгай зөвшөөрөл ирүүлэх эсэх.Шаардахгүй

Тендерийн хамт

1. Мах,хүнсний ногоо- 233.800₮ дүнтэй тендерийн баталгаа ирүүлэх
2. Нарийн боов,сүүн бүтээгдэхүүн- 46.700₮ дүнтэй тендерийн баталгаа ирүүлэх
3. Бусад хуурай хүнс- 161.900₮ дүнтэй тендерийн баталгаа ирүүлэх

Тендерийг **2020.02.10 -ны өдрийн 12.30 цаг**-аас өмнө цахим хаягаар ирүүлэх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан **2020.02.10-ны өдрийн 13 цаг 00 минут** -т нээнэ.

Дотоодын давуу эрх тооцох эсэх. Тооцно

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

**Дархан Уул аймгийн Хонгор сум 3-р баг Салхит хэсэг**

**11-р сургуулийн нягтлан бодогч Л.Мөнхтуяа 99370657**

Хоёр. **ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД ӨГӨХ ЗААВАРЧИЛГАА**

1. Эрх бүхий тендерт оролцогч ба эрх бүхий бараа
  2. Тендер ирүүлэх, тендерийн нээлт
  3. Тендерийн иж бүрдэл
  4. Гэрээний үнэ
  5. Техникийн тодорхойлолт ба арилжааны нөхцөлүүд
  6. Үнийн саналын хүчинтэй байх хугацаа
  7. Санал болгосон үнэ, түүнийг үнэлэх
  8. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл
- 1.1. Тендерт оролцогч нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 14-16 дугаар зүйл буюу Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт /цаашид “ТШӨХ” гэх/-д заасан холбогдох шаардлагыг хангасан байна.
  - 2.1. Захиалагч тендерүүдийг ТШӨХ-д заасан захиалагчийн хаягаар, ТШӨХ-д заасан огноо, цагаас өмнө хүлээн авна.
  - 2.2. Тендерийг ТШӨХ-д заасан хугацаанд, ТШӨХ-д заасан газар нээлтийг хийнэ.
  - 3.1. Тендерт оролцогчийн бэлтгэж ирүүлэх тендер нь дараах зүйлээс бүрдэнэ. Үүнд:
    - (а) Үнийн санал;
    - (б) Үнийн болон нийлүүлэлтийн хуваарь;
    - (в) Чадварын мэдээлэл /санхүүгийн тайлан, туршлагын мэдээлэл, гэрээ гүйцэтгэсэн ажлын гэрээний хуулбар/ болон бусад баримт бичиг;
    - (г) Шаардлагатай тусгай зөвшөөрөл;
    - (д) [Бэлтгэж ирүүлэх шаардлагатай бусад материалыг жагсаана.]
  - 4.1. ТШӨХ-д гэрээний үнийг тохируулах нөхцөлтэй байхаар тусгайлан зааснаас бусад тохиолдолд тендерт оролцогчийн санал болгосон үнэ нь гэрээний хэрэгжилтийн явцад тогтмол байна. Тендерийн үнийг гэрээний хэрэгжилтийн явцад тохируулж өөрчлөхөөр санал болгосон аливаа тендерийг ТӨӨЗ-ны 31 дүгээр зүйлд заасны дагуу үндсэн шаардлага хангаагүй тендер гэж үзэж, уг тендерээс татгалзана. Гэвч ТШӨХ-д үнэ тохируулахаар заасан нөхцөлд тогтмол үнэ санал болгосон тендерээс татгалзахгүй бөгөөд түүний үнийн тохируулга нь гэрээний хэрэгжилтийн явцад тэг (0)-тэй тэнцүү байна гэж үзнэ..
  - 5.1. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг тендерт оролцогч батлах үүрэгтэй. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагаас зөрсөн тохиолдолд тухайн тендерээс татгалзана.
  - 5.2. Тендерт оролцогч нь энэ баримт бичигт заасан арилжааны нөхцөлүүдийг бүрэн хангасныг албан бичгээр батлан тендерийн хамт ирүүлнэ.
  - 6.1. Үнийн санал нь түүнийг ирүүлсэн өдрөөс хойш **45** хоногийн хугацаанд хүчинтэй байна.
  - 7.1. Тендерт оролцогч үнийн саналдаа холбогдох бүх даатгал, тээврийн зардал, татвар, хураамжийг оруулж үнийн хуваарийн дагуу ирүүлнэ.
  - 7.2. Бараа нийлүүлэлтийн хуваарьт заасан бараа нь **ТШӨХ-д** заасан багцаас бүрдэх ба багцад орсон нэр төрөл бүрд заавал үнийн санал ирүүлнэ.
  - 7.3. Захиалагч техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл шаардлагыг хангасан оролцогчдын үнийг харьцуулж хамгийн бага үнэ санал болгосон тендерт оролцогчид гэрээ байгуулах эрхийг олгоно.
  - 8.1. Захиалагч нь шалгарсан тендерт оролцогчид гэрээ байгуулах эрх олгосныг түүний тендер хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө албан бичгээр мэдэгдэнэ. Энэ мэдэгдэлд гэрээнд заасны дагуу хийгдэх ажилд төлөх мөнгөн дүн буюу гэрээний үнийг заана. Гэрээний үнэ нь залруулга болон үнийн хөнгөлөлтийг (түүний дотор нөхцөлтэй үнийн хөнгөлөлт) тооцсон тендерийн үнэ байна.

**ГУРАВ.ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ӨГӨГДЛИЙН  
ХҮСНЭГТ**

Худалдан авах барааны талаарх дор дурдсан өгөгдлүүд нь тендерт оролцогчид өгөх зааварчилгаа/ТООЗ/-ны холбогдох зүйл, заалтын мэдээллийг гүйцээх, нэмэлт оруулах, эсхүл өөрчлөх зорилготой. Хэрэв ТООЗ-ны зүйл, заалттай зөрчилдвөл энэхүү хүснэгт дэх мэдээллийг зөв гэж үзнэ.

<b>ТООЗ-ны холбогдох заалт</b>	<b>А. Ерөнхий зүйл</b>
<b>ТООЗ 1.1</b>	Захиалагч нь: <i>ДУА-н Хонгор сумын 11-р сургууль</i>
<b>ТООЗ 1.1</b>	Нээлттэй тендер шалгаруулалтын нэр болон ялгагдах дугаар: Сурагчдын үдийн цай,хоол хүнсний материал нийлүүлэх <b>ДААХО11С/202012013</b>
<b>ТООЗ 1.2</b>	Энэхүү тендер шалгаруулалт нь дараах нэр, дугаар бүхий багцуудаас бүрдэнэ: <i>Багц 1 Мах , хүнсний ногоо-23.386.500₮</i> <i>Багц 2 Нарийн боов,сүүн бүтээгдэхүүн– 4.671.000₮</i> <i>Багц 3 Бусад хуурай хүнс – 16.185.700₮</i>
<b>ТООЗ 2.1</b>	Санхүүжилтийн эх үүсвэр нь: <i>Улсын төсвийн урсгал зардал-44.243.200₮</i>
	<b>Б. Тендерийн баримт бичиг</b>
<b>ТООЗ 8.1</b>	Захиалагчаас тендерийн баримт бичигтэй холбоотой тодруулга авах хаяг: <i>Дархан-Уул аймгийн Хонгор сумын 3-р баг 11-р сургууль <a href="mailto:tuyatuya64@yahoo.com">tuyatuya64@yahoo.com</a> утас 99370657</i>
<b>ТООЗ 8.1</b>	Тендерийн баримт бичгийн талаар тодруулга авах хүсэлтийг хүлээн авах хугацааны хязгаар тендер хүлээн авах эцсийн хугацаанаас ажлын [ <b>5 хоног</b> ] хоногоос багагүй байна. Тодруулгын хариуг цахим ХАА-ны системд <a href="http://www.tender.gov.mn">www.tender.gov.mn</a> д байршуулна. Тендерт оролцогч тодруулгыг цахим систем ашиглан шалгах үүрэгтэй.
	<b>В. Тендер бэлтгэх</b>
<b>ТООЗ 11.1</b>	Тендерийн хэл нь <b>Монгол</b> хэл байна.

<b>ТООЗ 12.1 (è)</b>	Тендерт оролцогч дараах нэмэлт материалыг өөрийн тендерт хавсралтаар ирүүлнэ. Үүнд: 1. Улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар /нотариатаар баталгаажуулсан/ 2. Татварын байгууллагын тодорхойлолт 3. ШШГ-н тодорхойлолт 4. Харилцагч банкны тодорхойлолт /банк тус бүрээр/ 5. Сүүлийн 1 жилийн санхүүгийн тайлан / 2019 / 6. Сүүлийн 1 жилийн туршлагын мэдээлэл/ ижил төстэй ажил гэрээгээр гүйцэтгэсэн гэрээний хуулбар, гэрээний дугаар/ 7. Тендерт оролцох мэдэгдэл, үнийн санал 8. Оролцогч компаны танилцуулга 9. Нийлүүлэх бараа бүтээгдэхүүнийг захиалагчийн техникийн тодорхойлолт тавигдах шаардлагын дагуу ханган нийлүүлэх тухай албан мэдэгдлийг эрх бүхий этгээдийн гарын үсэг зурж баталгаажуулах 10. Захиалагчийн гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлийг хүлээн зөвшөөрсөн албан мэдэгдэл.
<b>ТООЗ 14.1</b>	Хувилбарт тендер ирүүлэхийг <b>“зөвшөөрөхгүй”</b>
<b>ТООЗ 15.9 (б) (1) and (в) (3)</b>	Бараа хүргэгдэх газар: <b>Дархан-Уул аймгийн Хонгор сумын 3-р баг 11-р сургууль</b>
<b>ТООЗ 15.9 (а) (3);(б)(3)</b>	“Бараа хүргэгдэх эцсийн цэг: <b>Дархан-Уул аймгийн Хонгор сумын 3-р баг 11-р сургуулийн хүнсний агуулах</b>
<b>ТООЗ 15.10</b>	Тендерт оролцогчийн санал болгосон үнийг гэрээний хэрэгжилтийн явцад <b>үнэ тохируулахгүй</b>
<b>ТООЗ 16.1</b>	Тендерийн валют: <b>Төгрөг байна.</b>
<b>ТООЗ 18.1 (а)</b>	Үйлдвэрлэгчийн зөвшөөрөл: <b>“шаардлагагүй”</b>
<b>ТООЗ 18.1 (б)</b>	Санхүүгийн тайлан ирүүлэх жилийн тоо: <b>1 жил</b>
<b>ТООЗ 18.1 (г)</b>	Ижил төстэй ажил гэрээгээр гүйцэтгэсэн туршлагын мэдээлэл ирүүлэх жилийн тоо: <b>1 жил</b>
<b>ТООЗ 18.1 (д)</b>	Барааг нийлүүлсний дараах засвар, үйлчилгээ: <b>“шаардлагатай”. Техникийн тодорхойлолтын дагуу шаардлага хангаагүй барааг буцаан шинээр барааг</b>
<b>ТООЗ 18.2 (а)</b>	Борлуулалтын хэмжээ: <b>Сүүлийн 1 жил /2019 он/-ийн хугацаанд борлуулалтын орлого багцын үнийн дүнгийн 50%-иас багагүй байх</b>
<b>ТООЗ 18.2 (б)</b>	Гүйцэтгэгчээр ажилласан байх жилийн тоо: <b>1 жил</b>
<b>ТООЗ 18.2 (в)</b>	Гэрээг гүйцэтгэхэд зайлшгүй шаардлагатай үндсэн тоног төхөөрөмжийн жагсаалт: <b>шаардлагагүй</b>
<b>ТООЗ 18.2 (г)</b>	Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн хэмжээ: <b>Багцийн үнийн дүнгийн 40%-иас багагүй байх</b>
<b>ТООЗ 18.2 (д)</b>	Ашигтай ажилласан байх жилийн тоо: <b>1 жил</b>
<b>ТООЗ 18.4</b>	Дотоодын давуу эрхийн зөрүү: <b>“тооцно”</b>

<b>ТӨӨЗ 21.1</b>	<p>Тендерийн баталгааны үнийн дүн:</p> <p><b>Багц 1- Мах , хүнсний ногоо –233.800₮</b></p> <p><b>Багц 2-Нарийн боов,сүүн бүтээгдэхүүн-46.700₮</b></p> <p><b>Багц 3-Бусад хуурай хүнс-161.900₮</b></p> <p>[Төсөвт өргийн 1 хувиар баталгааны хэмжээг тогтоож үнийн дүнг оруулна.]</p> <p>Хүчинтэй байх хугацаа: 2019 он 03 сар 23 өдөр</p>
<b>ТӨӨЗ 22.1</b>	<p>Тендерийн эх хувиас гадна ирүүлэх хуулбар хувийн тоо: <b>Цахимаар</b></p>
<b>Г. Тендер ирүүлэх</b>	
<b>ТӨӨЗ 23.3 (б)</b>	<p>Тендер хүлээн авах захиалагчийн хаяг:</p> <p>Байгууллагын хаяг: <b>Дархан-Уул аймгийн Хонгор сумын 3-р баг 11-р сургууль</b>  <a href="mailto:tuyatuya64@yahoo.com">tuyatuya64@yahoo.com</a></p> <p>Давхар болон өрөөний дугаар: 2 давхар, захирлын <b>өрөө</b></p> <p>Аймаг, хот: <b>Дархан-Уул аймаг, Хонгор сум</b></p> <p>Улс: <b>“Монгол Улс”</b></p> <p>Уг тендер нь “Цахим тендер шалгаруулалт зохион байгуулах журам”-аар зохион байгуулагдаж байгаа тул тендерт оролцогч нь “Цахим худалдан авах ажиллагааны систем/<a href="http://www.tender.gov.mn">www.tender.gov.mn</a>/-д өөрийн аж ахуй нэжийн хувийн нууцлалын кодоор нэвтрэн орж тендерийн материалаа цахим хэлбэрээр ирүүлнэ.</p>
<b>ТӨӨЗ 23.3 (в)</b>	<p>Тендерт оролцогч нь тендерийн иж бүрдэл баримт бичгийг бэлтгэн электрон /Adobe PDF/ хэлбэрт шилжүүлж, цахим хэлбэрээр ирүүлнэ</p>
<b>ТӨӨЗ 24.1</b>	<p>Тендер хүлээн авах эцсийн хугацаа нь:</p> <p>Огноо: <b>2020 оны 02 дугаар сарын 10-ний өдөр</b></p> <p>Цаг: <b>12.00цаг 30 минут</b></p>
<b>Д. Тендерийг нээх, үнэлэх</b>	
<b>ТӨӨЗ 28.1</b>	<p>Тендерийн нээлт хийх газрын хаяг нь дор өгөгдөв. Үүнд:</p> <p>Байшин, гудамжны нэр: <b>3-р баг, 11-р сургууль</b></p> <p>Давхар болон өрөөний дугаар: 2 <b>давхар</b>, захирлын өрөө</p> <p>Аймаг, хот: <b>Дархан-Уул аймаг, Хонгор сум</b></p> <p>Улс: <b>“Монгол Улс”</b></p> <p>Тендерийн нээлт хийх огноо, цаг нь:</p> <p>Огноо: <b>2020 оны 02 дугаар сарын 10-ний өдөр</b></p> <p>Цаг: <b>13 цаг 00 минут</b></p>
<b>Е. Гэрээ байгуулах эрх олгох</b>	
<b>ТӨӨЗ 40.1</b>	<p>Захиалагч барааны тоо хэмжээг бууруулж болох хамгийн их хувь: <b>10 хувь</b></p> <p><b>Хичээлийн жилийн дундуур хүүхдийн өвчлөл ихсэх, хүүхдийн улирлын амралт, цаг агаарын өөрчлөлт зэрэг шалтгаанаас хүүхдийн тоо буурдаг.</b></p> <p>Нийлүүлэх барааны тоо хэмжээг өсгөж болох хамгийн их хувь: <b>2 хувь</b></p>

## Гурав. ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

### 1-р багц: Мах, хүнсний ногоо

1. Барааны тодорхойлолт: Монгол улсад үйлдвэрлэсэн
2. Стандарт: Эрүүл ахуй ариун цэврийн бичигтэй, гарал үүслийн гэрчилгээтэй, тухайн малчин өрхөд мал амьтны гоц халдварт болон халдварт өвчин гарч байгаагүйг тодорхойлсон мал эмнэлэгийн бичиг.
3. Баглаа, боодол: Стандартын дагуу гар аргаар нядалсан, шинжилгээнд хамрагдсан махыг, эрүүл ахуйн шаардлага хангасан тээврийн хэрэгслээр тээвэрлэж ирсэн байх шаардлагатай.
4. Бараа хүргэх газар: Дархан Уул аймгийн Хонгор сумын 11-р сургуулийн хүнсний складад няравт баталгаатай жин хэмжүүрээр тодорхойлуулж хүлээлгэж өгнө.
5. Барааны жагсаалт, нийлүүлэлтийн хуваарь

№	Барааны нэр	Тодорхойлолт	Захиалагчийн авах тоо хэмжээ	Х/н эгж	ТШӨХ-д заасан барааг хүргэх эцсийн цэг	Инкотермийн нөхцөлийн дагуу тогтоосон бараа нийлүүлэх хугацаа		
						Нийлүүлэх хамгийн эхний хугацаа	Нийлүүлэх эцсийн хугацаа	Нийлүүлэгчийн санал болгосон хугацаа
1	2	3	4	5	6	7	8	9
1	Үхрийн мах	<i>Цэвэр орчинд бэлтгэсэн, эрүүл ахуйн шаардлага хангасан чанартай, шинжилгээний бичигтэй.</i>	1800	кг	<i>11-р сургуулийн хүнсний склад</i>	2020.03.01	<i>дараагийн тендерийн гэрээ байгуулах хүртэл</i>	
2	Хонины мах		450	кг				
3	Тахианы мах		90	кг				
4	Төмс		1080	кг				
5	Байцаа		540	кг				
6	Лууван		225	кг				
7	Хүрэн, шар манжин		135	кг				
8	Сонгино		180	кг				
9	Чинжүү		90	кг				
10	Брокколи		90	кг				
11	Өргөст хэмх		135	кг				
12	Улаан лооль		45	кг				
13	Бууцай		18	кг				
14	Орос сармис		18	кг				

## 2-р багц: Нарийн боов,сүүн бүтээгдэхүүн

1. Барааны тодорхойлолт: Муудаж гэмтээгүй, чанарын шаардлага хангасан.
2. Стандарт: Чанарын өндөр шаардлага хангасан
3. Баглаа, боодол: Стандарт шаардлага хангасан сав, баглаа боодол, шошготой байх. Эрүүл ахуйн шаардлага хангасан бичиг.
4. Бараа хүргэх газар: Дархан Уул аймгийн Хонгор сумын 11-р сургуулийн хүнсний складад няравт кг-лах буюу жин хэмжүүрийг нь тодорхойлуулж хүлээлгэж өгнө.
5. Бараа нийлүүлэлтийн хуваарь:

№	Барааны нэр	Тодорхойлолт	Тоо шир хэг	Хэмжих нэгж	ТШӨХ-д заасан барааг хүргэх эцсийн цэг	Инкотермийн нөхцөлийн дагуу тогтоосон бараа нийлүүлэх хугацаа		
						Нийлүүлэх хамгийн эхний хугацаа	Нийлүүлэх эцсийн хугацаа	Нийлүүлэгчийн санал болгосон хугацаа
1	2	3	4	5	6	7	8	9
1	Цайны боов	Цавуулаг сайтай, 1-р зэргийн дотоодын үйлдвэрлэлийн гурилаар хийсэн печенэн болон гурилан боов,олон янзын хэлбэр,орцтой	360	ш	11-р сургуулийн хүнсний склад	2020.03.01	дараагийн тендерийн гэрээ байгуулах хүртэл	
2	Цөцгий	Монгол үйлдвэрлэсэн,эрүүл ахуйн шаардлага хангасан	27	кг				
3	Тараг	Монгол үйлдвэрлэсэн,эрүүл ахуйн шаардлага хангасан	540	л				
4	Шингэн сүү	Монгол үйлдвэрлэсэн,эрүүл ахуйн шаардлага хангасан	900	л				
5	Аарц	Монгол үйлдвэрлэсэн,эрүүл ахуйн шаардлага хангасан	135	кг				
6	Шар тос	Монгол үйлдвэрлэсэн,эрүүл ахуйн шаардлага хангасан	9	кг				

## 3-р багц: Бусад хуурай хүнс

1. Барааны тодорхойлолт: Муудаж гэмтээгүй, чанарын шаардлага хангасан.
2. Стандарт: Чанарын өндөр шаардлага хангасан
3. Баглаа, боодол: Стандарт шаардлага хангасан сав, баглаа боодол, шошготой байх. Эрүүл ахуйн шаардлага хангасан бичиг.

4. Бараа хүргэх газар: Дархан Уул аймгийн Хонгор сумын 11-р сургуулийн хүнсний складад  
 няравт кг-лах буюу жин хэмжүүрийг нь тодорхойлуулж хүлээлгэж өгнө.

5. Бараа нийлүүлэлтийн хуваарь:

№	Барааны нэр	Тодорхойлолт	Тоо ширхэг	Хэмж их нэгж	ТШӨХ-д заасан барааг хүргэх эцсийн цэг	Инкотермийн нөхцөлийн дагуу тогтоосон бараа нийлүүлэх хугацаа		
						Нийлүүлэх хамгийн эхний хугацаа	Нийлүүлэх эцсийн хугацаа	Нийлүүлэгчийн санал болгосон хугацаа
1	2	3	4	5	6	7	8	9
1	Гурил	Цавуулаг сайтай, Эрүүл ахуйн шаардлага хангасан, эрүүл ахуйн бичиг, 1-р зэргийн дотоодын үйлдвэрлэл	720	кг	11-р сургуулийн хүнсний склад	2020.03.01	дараагийн тендерийн гэрээ байгуулах хүртэл	
2	Эрүүл мэндийн гурил	Цавуулаг сайтай, Эрүүл ахуйн шаардлага хангасан, эрүүл ахуйн бичиг, 1-р зэргийн дотоодын үйлдвэрлэл	45	кг				
3	Баяжуулсан олон үрийн гурил	Монгол улсад үйлдвэрлэсэн / MNS - 0533 -1998 /, эрүүл ахуйн шаардлага хангасан, эрүүл ахуйн бичигтэй, чанарын баталгаатай.	45	кг				
4	Исгэгч / 1000гр /	460 -465 / 5550 -74 / Эрүүл ахуйн шаардлага хангасан, эрүүл ахуйн бичигтэй, чанарын баталгаатай	10	ш				
5	масло	Монгол улсад үйлдвэрлэсэн / MNS - 0533 -1998 /, эрүүл ахуйн шаардлага хангасан, эрүүл ахуйн бичигтэй, чанарын баталгаатай.	180	кг				
6	Молоко	Эрүүл ахуйн шаардлага хангасан, эрүүл ахуйн бичигтэй, чанарын баталгаатай.	54	ш				

7	Ургамлын тос	Орос улсынхтай дүйцэх чанар сайн, холестеринг үй Гост/1129 -2013/ байх Эрүүл ахуйн шаардлага хангасан, эрүүл ахуйн бичигтэй, чанарын баталгаатай.	180	л	11-р сургуулийн хүнсний склад	2020.03.01	дараагийн тендерийн гэрээ байгуулах хүртэл	
8	Элсэн чихэр	Орос улстай дүйцэх, ширхэг жижигтэй, чанар сайтай	135	кг				
9	Далайн байцаа / 550гр /	Эрүүл ахуйн шаардлага хангасан, эрүүл ахуйн бичигтэй, чанарын баталгаатай.	271	ш				
10	Давс	Иоджуулаагүй, эрүүл ахуйн бичигтэй	90	кг				
11	Цайны идээ	Монголд үйлдвэрлэсэн 0,5 гр савласан, үнэргүй	9	ш				
12	Нарийн гоймон / 300гр /	Монголд үйлдвэрлэсэн, янз бүрийн хэлбэртэй	135	ш				
13	Хөндий гоймон / 650гр /	Монголд үйлдвэрлэсэн, янз бүрийн хэлбэртэй	180	ш				
14	Цайны печень	Чанарын шаардлага Эрүүл ахуйн шаардлага хангасан, эрүүл ахуйн бичигтэй, чанарын баталгаатай.	720	ш				
15	Цагаан будаа	Хадгалах хугацааны стандартыг хангасан дээд зэргийн чанартай орос улсынхтай дүйцэхүйц	630	кг				
16	гурвалжин будаа	460- 465 Е-491 Эрүүл ахуйн шаардлага хангасан, эрүүл ахуйн бичигтэй, чанарын баталгаатай	45	ш				
17	Шар будаа	Монгол улсад үйлдвэрлэсэн / MNS - 0533 -1998 /, эрүүл ахуйн шаардлага хангасан, эрүүл ахуйн бичигтэй, чанарын баталгаатай.	45	кг				
18	Хөц будаа	Монгол болон бусад улсад үйлдвэрлэгдсэн, бага хэмжээгээр савлагдсан, төрөл олонтой байх	45	кг				

19	Хүүхдийн будаа	Эрүүл ахуйн шаардлага хангасан, чанарын баталгаатай.	45	кг	11-р сургуулийн хүнсний склад	2020.03.01	дараагийн тендерийн гэрээ байгуулах хүртэл	
20	ванилин	Эрүүл ахуйн шаардлага хангасан, чанарын баталгаатай.	27	ш				
21	Гурвалжин будааны няцалбар 0.5гр	Эрүүл ахуйн шаардлага хангасан, чанарын баталгаатай.	27	ш				
22	Хөц будааны няцалбар	Монгол болон бусад улсад үйлдвэрлэсэн, савлагатай	27	кг				
23	Овьёос	Эрүүл ахуйн шаардлага хангасан, чанарын баталгаатай.	90	кг				
24	Хатаасан сонгино	Эрүүл ахуйн шаардлага хангасан, чанарын баталгаатай.	90	кг				
25	Хатаасан сармис	Эрүүл ахуйн шаардлага хангасан, чанарын баталгаатай.	90	кг				
26	Варены	460-465 Шинжилгээний бичигтэй, хадгалалтын горим алдагдаагүй, хугацаа дуусаагүй байх	90	ш				
27	Сода	Хүнсэнд хэрэглэх зориулалт бүхий эрүүл ахуйн шаардлага хангасан шинжилгээний бичигтэй	9	ш				
28	Үзэм /орос /	Бор болон шар өнгөтэй, цэвэрхэн	72	кг				
29	Аньс жимс	Таримал болон өтгөрүүлсэн, монголд үйлдвэрлэсэн	130	кг				
30	Зөгийн бал	Таримал болон өтгөрүүлсэн, монголд үйлдвэрлэсэн	100	кг				
31	Нэрс жимс	Таримал болон өтгөрүүлсэн, монголд үйлдвэрлэсэн	150	кг				
32	Чацаргана жимс	Таримал болон өтгөрүүлсэн, монголд үйлдвэрлэсэн	150	кг				
33	Чангаанз	Эрүүл ахуйн шаардлага хангасан, чанарын баталгаатай.	150	кг				

Дөрөв. **ЖИШИГ МАЯГТ**

**1. ҮНИЙН САНАЛЫН МАЯГТ**

[огноо]

(Захиалагч байгууллагын нэр)-ын дарга \_\_\_\_\_ танаа

1. Бид, [тендерт оролцогчийн нэр] дор дурдсан барааг [санал болгож буй нийт үнийг тоогоор болон үсгээр] төгрөгөөр үнийн саналын авах баримт бичгийн дагуу [моо] хоногийн дотор нийлүүлэхээр санал болгож байна.
2. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг гэрчлэх баримтыг хавсаргав.
3. Бид гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлийг хүлээн зөвшөөрч байна гэдгийг үүгээр батламжилж байна.

Нэр төрөл	Тодорхойлолт	Барааны гарал үүслийн улс	Тоо ширхэг	Нэгж үнэ	Нийт дүн	НӨАТ болон бусад албан татвар	Бүгд дүн
1	2	3	4	5	6	7	8
Тендерийн нийт үнэ							

Баталгаат засварын хугацаа:

Санал болгож буй бусад нөхцөл:

Тендерт оролцогчийн нэр:

Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга:

Албан тушаал, нэр:

Хаяг:

## 2. НЭГДСЭН ХҮСНЭГТ: ӨМНӨ БОЛОН ОДОО ХЭРЭГЖИЖ БУЙ ГЭРЭЭ

Тендерт оролцогч хэрэгжүүлсэн болон одоо гүйцэтгэж буй бүх гэрээний талаар мэдээлэл ирүүлнэ.

Уг мэдээлэл нь гэрээ хэрэгжүүлэх чадавхгүй болсон эсхүл ажил дуусгавар болсон гэрчилгээ буюу ажил хүлээлцсэн актаа хүлээн авч байгаа гэрээний хувьд хамаарахгүй.

Гэрээний нэр	Захиалагч, холбоо барих хаяг/утас/фак с	Гэрээний үнийн дүн	Гэрээний эхлэх хугацаа	Гэрээний дуусах хугацаа
1.				
2.				
3.				
4.				
5.				
бусад.				

## Тав. ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

- |  |       |  |
|--|-------|--|
| 1. Шалгах болон турших                             | 1.1.  | Техникийн тодорхойлолтыг хангаж буй эсэхийг баталгаажуулах зорилгоор захиалагч эсхүл түүний төлөөлөгч барааг шалгах, турших эрхтэй. Гэрээний тусгай нөхцөл (ГТН)-д, эсхүл техникийн тодорхойлолтод захиалагч ямар шалгалт, туршилтыг хэзээ, хаана хийхийг заана.   |
| 2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт | 2.1.  | Нийлүүлэгдэх бараа нь техникийн тодорхойлолтод нийцсэн байх ба холбогдох стандартыг заагаагүй бол тухайн барааны гарал үүслийн улсын зохих стандартад нийцсэн байна. Үүнд эдгээр стандартын хамгийн сүүлчийн найруулгыг ойлгоно. Нийлүүлэгч ГТН-д заасан бол түүний дагуу тээврийн болон бусад баримт бичгийг бэлтгэж бүрдүүлнэ. |
| 3. Оюуны өмчийн эрх                                | 3.1.  | Бараа, эсхүл түүний эд ангийг өмчлөх, ашиглахад патент, худалдааны тэмдэг, зураг төслийн эрх гэх мэт оюуны өмчийн эрхийг захиалагч болон нийлүүлэгч зөрчсөн хэмээн гуравдагч этгээдийн нэхэмжилсэн гомдлыг нийлүүлэгч барагдуулж, холбогдон гарах зардлыг хариуцна.  |
| 4. Бараа хүргэх, тээврийн баримт бичиг ирүүлэх     | 4.1.  | Гэрээнд хэрэглэсэн үнэ болон бусад худалдааны нэр томъёог Инкотермс (INCOTERMS) буюу Парис хот дахь Олон улсын худалдааны танхимаас боловсруулж гаргасан сүүлийн хувилбарт тодорхойлсон утгаар ойлгоно.  |
| 5. Баталгаат засварын хугацаа                      | 5.1.  | Үйлдвэрлэгчийн тухайн бараанд олгодог баталгаат засварын хугацаа <b>[тоо]</b> жил байна.   |
| 6. Гэрээнд өөрчлөлт оруулах                        | 6.1.  | Гэрээний дагуу нийлүүлэгдэх барааны нэр төрөл, үзүүлэлтийг өөрчлөхгүй.   |
| 7. Төлбөр  | 7.1.  | Захиалагч төлбөрийг нэхэмжлэх хүлээн авснаас хойш <b>[ГТН-д заасан тоо]</b> хоногийн дотор шуурхай хийнэ.  |
| 8. Бараа нийлүүлэх хуваарь                         | 8.1.  | Нийлүүлэгч барааг хүргэхдээ техникийн тодорхойлолтод заасан бараа нийлүүлэлтийн хуваарийг мөрдөнө.   |
| 9. Алданги оногдуулах                              | 9.1.  | Захиалагч нийлүүлэгчийн хугацаа хоцорч нийлүүлсэн бараа, гүйцэтгэсэн үйлчилгээний гэрээний үнийн ГТН-д заасан хувьтай тэнцэх алданги оногдуулж, гэрээний үнийг тэр хэмжээгээр бууруулна. Алдангийн нийт дүн ГТН-д заасан дээд хэмжээнээс хэтрэхгүй.  |
| 10. Үүргээ биелүүлээгүй-гээс гэрээг цуцлах         | 10.1. | Нийлүүлэгч гэрээний үүргээ биелүүлээгүй тохиолдолд захиалагч гэрээг цуцалж, захиалагчид учирсан аливаа хохирлыг нийлүүлэгч барагдуулна.  |
| 11. Маргааныг шийдвэрлэх                           | 11.1. | Талууд гэрээний үүргийн биелэлттэй холбогдсон асуудлаар тохиролцоонд хүрч чадахгүй бол зохих тал шүүхэд нэхэмжлэл гаргана.   |

## Зургаа. ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ

1. Шалгах болон турших (ГЕН – 1) 1.1. [Гэрээний ерөнхий нөхцөлийн 1 дүгээр зүйлийг дэлгэрүүлэх шаардлагатай бол ямар шалгалт болон туршилтыг хэн, хэзээ хийх нөхцөлийг заана.]
2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт (ГЕН – 2) 2.1. Нийлүүлэгчийн бүрдүүлэх тээврийн болон бусад баримт бичгүүд:
- 1) нийлүүлэгчийн барааны нэр, тоо ширхэг, нэгж болон нийт үнийг заасан нэхэмжлэхийн хувь;
  - 2) барааг хүргэсэн тухай баримт, төмөр замын болон тээврийн баримт;
  - 3) үйлдвэрлэгчийн буюу нийлүүлэгчийн баталгаат засварын гэрчилгээ;
  - 4) үйлдвэрийн буюу эрх бүхий байгууллагын шалгалтын гэрчилгээ;
  - 5) барааны гарал үүслийн гэрчилгээ.
- Энд жагсаасан баримт бичгийг бараа хүрэлцэн ирэхээс өмнө захиалагчид өгсөн байна. Баримт бичгийг энэ хугацаанд захиалагчид өгч чадаагүйгээс гарах зардлыг нийлүүлэгч хариуцна.
3. Баталгаат засвар (ГЕН-5) 5.1. Баталгаат засварын тусгай шаардлага. Тухай бүр
- [Гэрээний ерөнхий нөхцөлийн 5 дугаар зүйл нь баталгаат засварын тухай нийтлэг заалтыг агуулна. Энэхүү нийтлэг заалтыг өөрчлөх шаардлага гарвал энд тусгана.]
4. Төлбөр (ГЕН – 7) 7.1. Гэрээний ерөнхий нөхцөлийн 7 дугаар зүйлийг дараах байдлаар дэлгэрүүлнэ. Үүнд:
- Гэрээний үнийн дүнгийн 100хувийг барааг хүлээн авсан акт болон гэрээний ерөнхий нөхцөлийн 2 дугаар зүйлд заасан баримт бичгийг үндэслэн төлнө.
5. Алданги оногдуулах (ГЕН - 9)<sup>1</sup> 9.1. Алданги оногдуулах хувь: **0,5**
- Алдангийн нийт дүн: **10 хувь**

<sup>1</sup> Ихэнх тохиолдолд ,нэг долоо хоногт оногдуулах алдинга гэрээний үнийн 0.5хувиас, алдангийн нийт дүнг эрээний үнийн дүнгийн 10 хувиас тус тус хэтрэхгүй.

**ЗАХИАЛАГЧ**

**НИЙЛҮҮЛЭГЧ**

\_\_\_\_\_ (Тамга, тэмдэг)

\_\_\_\_\_ (Тамга, тэмдэг)

\_\_\_\_\_ (Гарын үсэг)

\_\_\_\_\_ (Гарын үсэг)

\_\_\_\_\_ (Албан тушаал)

\_\_\_\_\_ (Албан тушаал)

**[Тендер шалгаруулалт/гэрээний нэр] гэрээ.**

Дугаар № [Тендер шалгаруулалт/гэрээний дугаар]

..... хот/аймаг

Нэг талаас **[захиалагчийн нэр]** (цаашид “захиалагч” гэх), нөгөө талаас **[нийлүүлэгчийн нэр]** (цаашид “нийлүүлэгч” гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож \_\_\_\_\_ оны \_\_ сарын \_\_\_\_ -ны өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

1. Монгол Улсын Иргэний болон бусад хууль тогтоомжийн дагуу бараа, бүтээгдэхүүн нийлүүлэхтэй холбогдон захиалагч, нийлүүлэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.
2. Захиалагч нь **[гэрээний нэр, дугаар]**-г (цаашид “бараа” гэх) **[гэрээний үнийг тоогоор болон үсгээр]** (цаашид “гэрээний үнэ” гэх) нийлүүлэхээр ирүүлсэн нийлүүлэгчийн тендерийг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.
3. Захиалагч нь барааны нийлүүлэлтийг \_\_\_\_\_ төгрөгийн улсын төсвийн хөрөнгөөр, \_\_\_\_\_ төгрөгийн орон нутгийн төсвийн хөрөнгөөр, \_\_\_\_\_ төгрөгийн өөрийн хөрөнгөөр санхүүжүүлнэ.
4. Нийлүүлэгч нь \_\_\_\_\_ нэр төрлийн барааг \_\_\_\_\_ оны \_\_ дугаар сарын \_\_\_\_ -наас \_\_\_\_\_ оны \_\_ дугаар сарын \_\_\_\_ -ны өдрийн дотор нийлүүлж хүлээлгэж өгнө.
5. Дор дурдсан баримт бичиг нь гэрээний салшгүй хэсэг болно (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:

Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;  
Бусад шаардлагатай баримт бичиг<sup>3</sup>;  
Үнийн санал;  
Гэрээний тусгай нөхцөл;  
Гэрээний ерөнхий нөхцөл;  
Техникийн тодорхойлолт болон бараа нийлүүлэлтийн хуваарь;  
Санхүүжилтийн хуваарь.

<sup>2</sup> Гэрээбайгуулахүедүүнийгхасна.

<sup>3</sup> Хоёрталхарилцантохиролцожгэрээнийнөхцөлдоруулсанзайлшгүйшаардлагатайнэмэлт, өөрчлөлтүүд.

Гэрээ нь энд дурдсан барааны нийлүүлэлтийн талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний баримт бичгүүд хоорондоо зөрчилдвэл дээр дурдсан дарааллын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.

6. Нийлүүлэгч нь энэ гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан барааг нийлүүлж, гэмтэл согог арилгах үүрэг хүлээнэ.
7. Захиалагч нь гэрээний дагуу нийлүүлэгчийн нийлүүлэх бараа болон гэмтэл согог арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний үнэ, эсхүл тухайн үед гэрээний заалтын дагуу төлөх бусад дүнг гэрээнд заасан хэлбэрээр нийлүүлэгчид төлөх үүрэг, хүлээнэ.
8. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр буюу шуудан, телекс, цахилгаан болон факсаар харилцана.

**ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:**

*[Албан тушаал, нэр]*  
*[Гарын үсэг]*\_\_\_\_\_

ТАМГА

*[Захиалагчийн хаяг]*  
*[Утас/факсын дугаар]*  
*[Харилцагч банкны нэр, дансны дугаар]*

**НИЙЛҮҮЛЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:**

*[Албан тушаал, нэр]*  
*[Гарын үсэг]*\_\_\_\_\_

ТАМГА

*[Захиалагчийн хаяг]*  
*[Утас/факсын дугаар]*  
*[Харилцагч банкны нэр, дансны дугаар]*